



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

“Батс ҮЦК” ХХК арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны Улсын байцаагчийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 137 тоот албан шаардлагыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн “Батс ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 2 сар хүртэл хугацаагаар түр түдгэлзүүлсүгэй.
2. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг хаах ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

1522030161